

## Программ суулгах ажилж эхлэх талаар гардаг нийтлэг асуултууд

1. Нэр нууц үгээ мартчихлаа нэр нууц үгийг шинээр олгоно уу?
2. хамр-control.exe-г ажиллуулан Apache, Mysql-г Start хийсэн ч Apache нь Running гэж гарч ирэхгүй байна яах вэ?
3. Программд хэрэглэгчийн нэр нууц үгээ оруулан нэвтрэх гэхээр эргэж нэр нууц үг нэхсэн цонх гараад байна яаж нэвтрэх вэ?
4. Программ зүгээр эхэлсэн ч <http://localhost/> гэж ороход программ руу орохгүй интернэтээр localhost гэсэн хайлт хийгдээд байна программ руугаа яаж орох вэ?
5. Программ руу орох үед Work offline, Connect to, Try again гэж дахин дахин асуугаад байна.
6. Программ дээр ажиллах үед хадгалагдахгүй байна яах вэ?
7. Би өөрийнхөө зөөврийн компьютер дээр тайлангаа хийж байгаа юм. Гэтэл цалин шивэх гэтэл тоо шивэгдэхгүй зарим нэг тоо л ороод байна яах вэ?
8. Хүний зураг оруулахад буруу зураг оруулсан тохиолдолд засаж оруулж болохгүй байна яах вэ?

### 1. Нууц үг, нэрээ мартчихлаа...


ТАЗ-ийн ажилтнууд таны нэвтрэх нэр нууц үгийг мэдэхгүй. Уг мэдээлэл нь зөвхөн таны компьютер дээр хадгалагддаг мэдээлэл юм. Иймд ТАЗ-өөс нэр нууц үгийг өгөх боломжгүй. Хэрэв та нэр нууц үгээ мартсан бол ТАЗ-ийн вэб сайтнаас системийн гарын авлага файлыг татан авч холбогдох хэсгийг үзнэ үү.

### 2. Apache эхлэхгүй бол

Хэрэв Apache нь Start товчийг дарсан ч Running гэж гарч ирэхгүй, эсвэл гараад 1,2 секунд болоод арилаад байвал өөр юуны өмнө хамрр хавтасыг C:/ диск дотор хуульж тавьсан эсэхээ дахин нягтална уу. D: дотроос юмуу өөр газарт хуулагдсан байвал ажиллахгүй.

Хэрэв хамрр-г C:/ дотор хуулсан бөгөөд түүн дотроос хамр-control.exe-г ажиллуулсан бол өөр ямар нэгэн программ Apache-тай адил 80 дугаарын портыг ашиглан ажиллаж байгаагаас Apache ажиллахгүй байх магадлалтай. Жишээлбэл Skype программ ажиллаж байвал түүнийг хаах хэрэгтэй. Хэрэв Skype ажиллаагүй ч Apache нь Start хийхгүй байвал өөр бусад ажиллаж байгаа программуудыг хаан Restart хийх хэрэгтэй. Тухайн программыг систем эхлэхэд ажиллахыг болиулах


бол: Start > Run гээд “msconfig” гэж бичээд(хашилтгүйгээр) enter дараад Startup хэсэг рүү орно.



Startup дотор байгаа нэрсээс тухайн программыг сонгон урд талын нүдэн дахь тэмдэглэгээг арилгана. Өөрөөр хэлбэл программын нэрийн урд зөв тэмдэг тавигдсан байгаа программ систем эхлэхэд ажиллаж эхэлнэ гэсэн үг юм.

### 3. Нэр нууц үг дахин дахин нэхээд байвал


Internet Explorer 9 хувилбар дээр HRMS программ нэр, нууц үгээс цааш нэвтрэхгүй байгаа асуудал гарч байгаа. Энэ асуудлыг шийдэхдээ Internet Explorer дээр ажиллаж байхдаа F12 товчийг гараас дараад



Дэлгэцийн доод хэсэгт харагдах Browser Mode: IE9 гэснийг дарж IE8 болгосны дараа нэвтэрнэ үү.



## 4. Localhost гэсэн хайлт хийгдээд байвал

Жич: Хэрэв программ дээрх маягаар асуудалгүй ажиллаж байгаа боловч **Internet Explorer** нээж хаягын мөрөн дээр `http://localhost/` гэж бичихэд дараах байдалтай localhost түлхүүр үгээр хайлт хийгдэн, хүний нөөцийн систем ажиллахгүй байгаа тохиолдолд Yahoo search protection, Sweet IM toolbar for Internet Explorer зэрэг программууд системд суусан байх магадлалтай тул эдгээрийг системээс арилгах шаардлагатай.



Эдгээр программыг системээс арилгахдаа:

Start>Control Panel> Add or Remove Programms гэж ороод холбогдох программыг сонгоод Remove дарна.




Мөн энэ төрлийн бусад программаас болж ажиллахгүй байвал дээрх жагсаалтаас тэдгээр программыг сонгон Remove хийх хэрэгтэй.


## 5. Internet Explorer-оор ороход Work offline, Connect to, Try again гэж байнга гарч ирэх нь төвөгтэй байна, хөнгөвчлөх арга байна уу?

Хэрэв Internet Explorer-оор ороход Work offline, Connect to болон Connect to, Try again гэсэн сонголтууд байн байн гарч ирэн тухай бүр Connect to гэх зэргээр сонголт хийж цааш үргэлжлүүлэх хэрэгтэй болоод байгаа бол:

Tools->Internet Options гэж ороод (Internet Explorer 6 ба 8 дээр харагдах байдлыг доор зэрэгцүүлэн үзүүлэв) IE6 дээр Programs руу, IE8 дээр Advanced руу ороод харгалзан Reset Web Settings ба Reset... –г дарна.



Ингэхэд дараах байдлаар харагдах ба Yes эсвэл Reset –г дарна.



Компьютерээ унтраагаад асаана.

## 6. Программ дээр ажиллах үед хадгалагдахгүй байвал

Хэрэв программд мэдээлэл оруулаад хадгалах гэхэд хадгалагдахгүй эсвэл гараад буцаад ороход хадгалагдаагүй утсан байвал

[http://csc.gov.mn/main/index.php?option=com\\_content&view=article&id=274&Itemid=47](http://csc.gov.mn/main/index.php?option=com_content&view=article&id=274&Itemid=47)

Хаяг руу орж хамрр программ татах гэсэн хэсгээс программыг шинээр татаж авч суулгана уу. Ингэхдээ хуучин баазыг хадгалж, шинэ програм руу зөөвөрлөх зааврыг сайтар уншина уу.



## 7. Notebook дээр ажиллах үед тоо шивэгдэхгүй байна.

Хэрэв зөөврийн компьютер(Notebook) дээр тайлангаа хийж байгаа бол цалинг шивж оруулахад тоонууд ажиллахгүй байх тохиолдол гарна. Энэ үед ихэвчлэн гарын зүүн доод өнцөгт байрлах хөх өнгөөр Fn гэж бичсэн товчийг мөн адил хөх өнгөөр NumLK гэж бичсэн товчтой хамт дарна. Ингэснээр гарын үсэгнүүдийн (U,I,J,K гэх мэт үсгүүд) дээд өнцөгт хөхөөр бичсэн тоонуудыг идэвхжүүлэх горимд орно. Ингэснээр эдгээрийг ашиглан цалингаа оруулах боломтой болно. Энэ горимоос гарахдаа Fn+Num LK товчны хослолыг ахин дарах хэрэгтэй.

## 8. Нэгэнт оруулсан зураг солигдохгүй байвал

Хэрэв Internet Explorer 8 дээр ажиллаж байх тохиолдолд оруулсан зураг солигдохгүй байгаа бол:

Tool-> Internet Options гэж ороод General хэсгийн Delete...-г дараад



дээд талын 4-ийг зөвлөсөн байгааг баталгаажуулаад Delete-г дарна. Уншиж дууссаны дараа компьютерээ унтраагаад асаана.